# ХОВД АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **Зорилго 1.** Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана. | | | | | | | | |
| 1.1.1 | *БГТ 1.2.3* Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | - | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | - | 2025 оны эхний хагас жилд Дөргөн, Мянгад, Дуут сумуудад газар дээрх хяналтыг хийж хэрэгжүүллээ. Анхан шатны 21 эрүүл мэндийн төвүүдэд сар бүр тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналт хийж 250,4 сая төгрөгний хасалт хийж ажилласан байна. Хасагдлын шалтгаанд дүн шинжилгээ хийж улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа. | 100% |
| 1.1.2 | *БГТ 1.2.4* Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл | | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | - | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна. | | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ирсэн шинэчлэгдсэн тогтоолууд, сургалт сурталчилгааны хэвлэмэл хуудсыг гэрээт 74 эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд тараах материалаар түгээж сурталчлан ажилласан. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудас болон орон нутгийн пэйж хуудсаар олон нийтэд мэдээллүүдийг цахимаар тухай бүр хүргэж ажиллаа. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | | | | | | | |
| 1.1.3 | "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | | Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журмыг хэрэгжүүлсэн байна. | | Лавлагаа шатлалын 8 эрүүл мэндийн байгууллагуудад Шинэчлэн баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03, 04, 10 дугаар тогтоолууд, эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 04/548 тоот албан бичгийн хамт хүргүүлэн ажилласан. ЭМДЕГ-аас хийсэн шиэчилсэн тогтоолыг танилцуулах цахим сургалтад лавлагаа шатлалын 8 ЭМБ-ийн эмч мэргэжилтнүүдийг хамруулллаа. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 70 гаруй эмч мэргэжилтэнд танхимын нэгдсэн сургалт, Дөргөн, Дуут,Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад, сумын эрүүл мэндийн төвийн нийт 256 эмч ажилчдад шинэчлэгдсэн 03,04, 10 тогтоол, 6 настны эрт илрүүлэг үзлэгийн талаар газар дээрх сургалт хийж зөвлөн тусалж, мэдээллээр хангаж ажиллаа. | 100% |
| 1.1.4 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг | | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна. | | Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шинэчлэн баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03, 04, 10 дугаар тогтоолуудыг эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 01/550 тоот албан бичгийн хамт хүргүүлэн ажилласан. Мөн 6 өрхийн эрхлэгч эмч, 15 сумын эрүүл мэндийн төвийн 70 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, Дөргөн, Дуут,Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад, сумын эрүүл мэндийн төвийн нийт эмч ажилчдад шинэчлэгдсэн 03,04, 10 тогтоол, 6 настны эрт илрүүлэг үзлэгийн талаарх сургалт зохион байгууллаа. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | | | | | | | |
| 1.1.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | | Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо | 13019 даатгуулагчийг хамруулж 1.5 тэрбум төгрөгний санхүүжилт олгосон | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний нэхэмжлэлийг эхний 4 сарын байдлаар 2 эрүүл мэндийн байгууллагаас хүлээн авч, гүйцэтгэлд хяналт хийж 2960 иргэний 489 сая төгрөгийн санхүүжилтийг баталгаажуулж санхүүгийн хэлтэст хүргүүлсэн байна | 100% |
| 1.1.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт | | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | | Булган сумын нэгдсэн эмнэлэгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас шинжилгээ хийж, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон , саналуудыг ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.<br>Суманд ажилладаг лавлагаа шатлалын эмнэлэгүүдэд мөрдөх стандарт баталж өгнөүү гэсэн саналыг уламжиллаа | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлнэ. | | | | | | | |
| 1.1.7 | "ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо -Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | - | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 42 эмийн санд жагсаалтыг хүргүүлэн хяналт тавьж ажилласан | | Гэрээт 44 эмийн санд ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах, 2024 оны гэрээгээ хангалтгүй дүгнүүлсэн 15 эмийн санд албан шаарлага хүргүүлэн, албан шаардлагын биелэлтийг хангуулж ажиллаа. Дөрөн, Эрдэнэбүрэн, Чандмань, Ховд, Мянгад, Дуут, Мөнхийн тун зэрэг 8 эмийн сангийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт хийж алан шаардлагын биелэлтийг хангуулан ажиллаа. | 100% |
| **Зорилт 1.4.** Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно: | | | | | | | | |
| 1.2.1 | *БСТ 2.1.3, БГТ-1.4.3* Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | Хүргүүлсэн саналын тоо | 1 санал хүргүүлсэн | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | – | Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төлөвлөх журам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчид нэмэгдэл олгох журам, Нийгмийн халамжийн тухай хуульд тус тус санал хүргүүллээ. | 100% |
| 1.2.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд | - | Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн | Зөрчлийн хэргийн тоо-0 Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн-0 | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | – | Прокурорын байгууллагаас ирүүлсэн 2 албан бичгийн дагуу гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон 186 иргэдийн 163,9 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын сангаас авсан тусламж үйлчилгээний судалгааг гарган хүргүүллээ. Мөн иргэний нэхэмжлэгчээр 4 удаа шүүх хуралд оролцож даатгалын санд нэр бүхий 4 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана. | | | | | | иргэний 23.450.880 төгрөгийг буцаан төлүүлэн хамтран ажилласан. Цагдаагийн байгууллагтаа хамтран 56 иргэний хэрэгт нэхэмжлэгчээр оролцож прокурорт хэргийг шилжүүлээд байна. | |
| **Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | | |
| Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 2.1.1 | ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1<br><br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 70% | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 85% дээш | – | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/12 тоот тушаалаар баталсан эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөнд эхний 4 сарын байдлаар 3661 даатгуулагчийг хамруулах төлөвлөгөөтэйгөөс 3241 иргэнийг хамруулж 89%-ийн биелэлттэй байна. Үүнээс их дээд сургуулийн өдрийн ангийн суралцагч 350 хамрагдахаас 1034 хамрагдаж 295%, малчин 1950 хамрагдахаас 1102 хамрагдаж 57%, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 1341 хамрагдахаас 1094 хамрагдаж 82%, гадаадын иргэн 20 хамрагдахаас 11 хамрагдаж 55%, аж ахуй нэгж байгууллагын ажилтан 12860 хамрагдахаас 12012 хамрагдаж 93,4% -ийн биелэлттэй гарсан байна. | 100% |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 80% | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100% | | | |
| | | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 71,5% | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 90% дээш | | | |
| | | | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 83.9% | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 100% | | | |
| 2.1.2 | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | 2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна. | | Хэлтсийн 2024 жилийн эцсийн санхүүгийн тайланг 1 дүгээр сард гэрээ бүхий 73 байгууллагатай нэг бүрчлэн өглөг авлагын тооцоо нийлж тулган баталгаажуулж санхүүгийн хэлтэс хүргүүлсэн. Энэ оны 1-р | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | | | хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн. | | | улирлын санхүүгийн тайланг гаргахаар бэлтгэл хангаж ажиллаж байна. | |
| 2.1.3 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,* Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | | Төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2024 оны орлогын төлөвлөгөөн ий биелэлт 83,9 хувьтай байна. | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | | Эхний 5 сарын байдлаар шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн 463.1 сая төгрөг, аж ахуй нэгжийн албан хаагчдын 4.5 тэр бум төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөө 96.9%-ийн биелэлттэй байна. | 100% |
| Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална. | | | | | | | | |
| 2.2.1 | *БСТ 2.2.1, БГТ-2.2.1* Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | ЭМДС | Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан | Өглөг 3,1 тэрбум, авлага байхгүй | Өглөг, авлага барагдуулах чигэлэээр арга хэмжээ авч ажилласан байна | – | Хэлтсийн урьд оны өглөг болох 6 тэр бум төгрөгийн өглөгийг барагдуулсан. Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлд сар бүр хяналт тавьж, сар бүрийн төсөвт тулгалт хийж ажиллаж байна. | 100% |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна** | | | | | | | | |
| Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | *БСТ 3.1.2, БГТ 3.1.1* Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | | Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо | 74 гэрээт эрүүл мэндийн байгууллагыг дүгнэсэн. | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй. | – | Тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлтийг А/61 тушаалын дагуу үнэлэхэд лавалагаа шатлалын 8 эрүүл мэндийн байгууллага гэрээний биелэлтийн үзүүлэлтээр Мөнхцохилохуй эмнэлэг 85, Булган нэгдсэн эмнэлэг 81.5, Ач заяа эмнэлэг-75, Мөнгөн морьт эмнэлэг 75, Ивээл уламжлалтын эмнэлэг 80, Жаргалант удам уламжлалтын эмнэлэг 85, Очир сүлд эмнэлэг 75, Бүсийн оношилгоо эмчилгээний төв 81.2 оноотой тус тус дүгнэгдсэн бөгөөд 75-85 оноотой дүгнүүлсэн дээрх эмнэлгүүдэд улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажиллав. Анхан шатны гэрээ бүхий 21 эрүүл мэндийн төвүүдээс 90-99,6 буюу маш сайн үнэлгээтэй өрхийн эрүүл мэндийн төв-3, сумын эрүүл мэндийн төв-1, 70-89,9 буюу хангалттай үнэлгээтэй өрхийн эрүүл мэндийн төв-3, сумын эрүүл мэндийн төв-11, 61.8-69.8 буюу хангалтгүй үнэлгээтэй сумын эрүүл мэндийн төв-3 тус тус дүгнэгдлээ. Гэрээт 43 эмийн сангаас 29 эмийн сангийн гэрээг дүгнэхэд 90-95%-тай 5, 80-85%-тай 9, 65-75%тай 7 эмийн сан үнэлгдэж хангалтгүй үнэлэгдсэн 7 эмийн санд албан шаардлага хүргүүлж 15 эмийн сангийн эрхийг түр түдгэлзүүлж зөрчил арилгаж ажиллаа . | 100% |
| | | | 74 ЭМБ | Гэрээний хэрэгжилт 86,7 хувь | | | | |
| 3.1.2 | 2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн | | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо | Өрхийн ЭМТ-6, Сумын ЭМТ-15, Эмийн сан-43 | Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан | | Гэрээ дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн 6 өрх, 15 сумын ЭМТ, 6 хувийн хэвшил, 2 улсын эмнэлэг, 23 эмийн сан, шинээр хүсэлт ирүүлсэн 1 нийт 57 ЭМБ-уудтай гэрээ байгуулж, хангалтгүй үнэлэгдсэн 15 эмийн сангийн зөрчлийг арилгуулж 2 дугаар сараас гэрээ байгуулан ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудт ай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | | | | байна. | | | |
| 3.1.3 | Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг хангаН ажиллана | | | | | | ЭМДЕГ-аас хийсэн шиэчилсэн тогтоолыг танилцуулах цахим сургалтад лавлагаа шатлалын ЭМБ-ийн эмч мэргэжилтнүүдийг хамруулав. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 70 гаруй эмч мэргэжилтэнд танхимын нэгдсэн сургалт, Дөргөн, Дуут,Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад, сумын эрүүл мэндийн төвийн нийт 146 эмч ажилчдад шинэчлэгдсэн 03,04, 10 тогтоол, 6 настны эрт илрүүлэг үзлэгийн талаар газар дээрх сургалт хийж зөвлөн тусалж, мэдээллээр хангаж ажиллаа. | 100% |
| Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна | | | | | | | | |
| 3.2.1 | *БГТ 3.2.1* Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагууда д нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | ЭМДС | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн, | 70 ЭМБ 472618 хүний 41,2 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан. | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна. | – | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 4 мэргэжилтэнд түүвэрлэгдсэн 396 эрүүл мэндийн байгууллагын 10279 түүвэрт нарийвчилсан хяналт хийж 326,1 сая төгрөгний хасалт хийж ажиллаа. Анхан шатны 21 эрүүл мэндийн төвүүдээс 713 хүний 250,4 сая төгрөгний хасалт хийж ажилласан байна. | 100% |
| 3.2.2 | *БГТ 3.2.3* Гэрээт эрүүл мэндийн байгууллагад | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын | 2024 онд 5 ЭМБ-д зөвлөн туслах | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах | | 2024 оны гэрээ дүгнэхэд 61.8-69.8 буюу хангалтгүй үнэлгээтэй дүгнэдгдсэн Дөргөн, Ховд, Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төв дээр очиж үнэлгээнд тулгуурлан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | | тоо | үйлчилгээ үзүүлсэн. | үйлчилгээг үзүүлсэн байна. | | зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж сургалт зохион байгууллаа. Мөн 75-85 оноотой дүгнүүлсэн д эмнэлгүүдэд улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж ажиллав. | |
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | - | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 44 зөвлөмж хүргүүлсэн, хэрэгжилтийн хувь 75% | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | | Жилийн эцсийн гэрээ дүгнэхэд 80-аас доош үнэлэгдсэн гэрээ бүхий 20 эмийн санд улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн Лавлагаа шатлалын ЭМБ-дын 2024 оны 7-12 саруудын хасагдлын шалтгааныг дүгнэж, улсын байцаагчийн зөвлөмжийг хавсралтын хамт хүргүүлж зөвлөн тусалж ажиллаа. | 100% |
| 3.2.4 | *БСТ 3.2.3, БГТ-3.2.2* Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, санал үндэслэн эрүүл мэндийн байгууллагууда д газар дээрх хяналт шалгалт хийнэ. | - | Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан | - | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | | Худалдан авалт гэрээлэлтийн газраас ирүүлсэн дотоод албан бичгийн дагуу Мянгад, Дөргөн, сумын эрүүл мэндийн төвүүдэд шүдний тусламж үзүүлэх чадамжийг үнэлэх газар дээрх хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн танилцуулга дүгнэлтийг хүргүүллээ. Иргэн даатгуулагчаас ямар нэгэн гомдол саналгүй ажилалаа. | |
| **Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | | |
| 4.1.1 | *ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3* Ажилтнуудын | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний | Ахлах түшмэлийн сургалтанд 1 | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн | | Авлигалтай тэмцэх газраас зохион байгуулсан ХАСХОМ бөглөх сургалт, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | | тоо, тайлан | мэргэжилтэн, богино хугацааны сургалтанд 3 мэргэжилтэн хамрагдсан | байна. | | авлигалын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх сургалт 1 албан хаагч Удирлагын акдемийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтанд хамрагдаж төгссөн байна. | |
| 4.1.2 | *БГТ 4.1.4* Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | - | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан. | Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | | ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тогтоолуудын танилцуулга, , анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагагуудтай хийх гэрээний сургалтууд, 6 настнуудын эрт илрүүлэгийн сургалт, мэдээллийн цаг зэрэг ерөнхий газраас зохион байгуулсан мэдээллийн цаг сургалтуудад тус тус хэлтсийн хамт олон 100% хамрагдсан байна. | 100% |
| 4.1.3 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг,сургалт , сурталчилгааны | - | Зохион байгуулсан арга хэмжээ-17 | Зохион байгуулсан арга хэмжээ-2, сургалтын тоо-3 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | | Аймгийн засаг даргын төрийн байгууллагуудын удирдлагуудад зохон байгуулдаг шуурхай хурлын мэдээллийн цаг дээр салбарын хууль тогтоомж, шинэчилсэн тогтоол, шимтгэлийн хувь хэмжээг танилцуулсан мэдээлэл хийв. Мөн Дөргөн, Мянгад суманд олон нийтэд эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалтыг зохион байгууллаа. ЭМДШ-ын орлогыг нэмэгдүүлэх талаар аймгийн төвийн жаргалант сумын 12 багийн дарга нарт мэдээлэл хүргэж хамтран ажиллахаар боллоо. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бусад арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | | |
| 4.1.4 | БГТ 4.1.10 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 112 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна | | ОНХХ-с ирүүлсэн сэтгэл ханамжийн судалгаанд гэрээт ЭМБ-ын 206 ажилтан хамруулж дүн шинжилгээ хийж ажилалаа. | 100% |
| 4.1.5 | *БГТ 4.1.15* Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл гомдолыг хуулийн хугацаанд үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнах | - | Албан бичиг өргөдөл гомдлын тоо шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 104, шийдвэрлэлт 100 хувь. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна | | Хэлтэст ирсэн иргэний 28 өргөдлийг хуулийн хугацаанд үнэн зөв шийдвэрлэж хариу мэдэгдэж ажиллаа. Мөн Засгийн газрын 1111 мэдээллийн утсанд гэрээт байгууллагатай холбоотой 1 гомдол ирснийг холбогдох байгууллагат шилжүүлж хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэнд хариу мэдэгдлээ. Хурууны хээтэй холбоотой 56 иргэний мэдээллийг НХХ-т хянаж хүргүүлж хүсэлтийг шийдвэрлүүллээ. | 100% |
| 4.1.6 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг | | Өгсөн үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь. | ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг | удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 100 хувь хэрэгжүүлсэн байна. | | Шуурхай хурлаас өгөгдсөн 16 үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухайд нь гаргаж хүргүүлсэн. Мөн удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаварыг тухай бүр хэрэгжүүлж ажиллаа | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж ажиллана. | | | 100 хувь хэрэгжүүлсэн байна. | | | | |
| 4.1.7 | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар болон хэлтсийн дотооддоо хийж гүйцэтгэсэн ажлуудын хэрэгжилтийг хангаж биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнана. | | Үүрэг даалгаврын тоо , хэрэгжилтийн хувь | Үүрэг даалгаврыг биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. | удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар болон хэлтсийн дотооддоо хийж гүйцэтгэсэн ажлуудын хэрэгжилтийг хангаж биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнасан. | | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь гүйцэтгэж ажиллаа. сумуудад хийх сургалтын хөтөлбөр, сумын эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүдэд хийх сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, хөтөлбөрийн дагуу сургалт хийж ажиллаа. Аймгийн засаг даргаас өгсөн 15 үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж хүргүүлсэн. ЭМДЕГ-ын удирдамжийн дагуу сумдад томилолтоор ажиллаж хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж ажиллаа. | 98% |
| 4.1.8 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний | Хэлтсийн мэргэжилтэн ий гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | | Хэлтсийн чанар төлбөрийн хяналтын 3 мэргэжилтний 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж төлөвлөгөөний биелэлтийг оны эхнээс жигд ханган биелүүлэхэд зөвлөн ажиллаж байна. мөн хэлтсийн хийж гүйцэтгэх ажил үүргийг ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжилтнүүдэд хувиарлаж ажлын ачааллыг тэнцүүлэн өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж байна. | 90% |
| 4.1.9 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг | - | Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо | 2024 оны 12 архивын нэгжийг | Албан хэрэг хөтлөлтийн үйл | | Хэлтэст ирсэн, явсан бичиг , дотоод албан бичиг нийт 108 албан бичгийг хүлээн авч тухай бүр бүртгэлжүүлэн хөтөлж албан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | стандарт, заоврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө. | | | бүрдүүлж, албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн | ажиллагааг стандарт, заоврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна | | бичгийн хариуг хугацаанд нь хүргэж ажилласан. 2024 оны гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын анхан шатны баримтуудыг архивын 12 боть үүсгэж архивласан. | |
| 4.1.10 | Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйл ийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн , 2025 оны 1 сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | - | Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо. Хэрэгжилтийн хувь | | Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж зохих бэлтгэл хангасны дараа кирил болон хос бичгээр хөтлөн явуулна | | Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангаж абле-д монгол бичигтэй албан бланкаа байршуулж бэлэн болгоод байна. Крилл бичгийг монгол бичгээр хөрвүүлэх праграмм ашиглалтанд оруулж 4,1-с албан бичигээ хос бичгээр гаргаж эхэлсэн. | 70% |
| 4.1.11 | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ | - | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо | | Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх хүлээн авах хадгалах үйл ажиллагагнд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна. | | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэн дотоод албан бичиг болон цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг бүрэн цахимжуулж ажиллаж байна. Тоон гарын үсэгээ үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн ашиглаж байна. | 100% |
| 4.1.12 | Авилгатай тэмцэх үндэсний | | Хэрэгжилтийн хувь. | | Хуулийн хугацаанд ХАСХОМ, | | Хэлтсийн албан хаагчид хуулийн хугацаанд ХАСХОМ-ээ 100 хувь мэдүүлсэн ба Авлигалтай тэмцэх газраас зохион | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаан ажиллана. | | | | ХАСХУМ-ээ 100 хувь мэдүүлсэн байх | | байгуулсан ХАСХОМ бөглөх сургалт, авлигалын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх сургалтад тус тус хамраглаа. | |
| **5. Төрийн албаны тухай хууль салбар хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд.** | | | | | | | | |
| 5.1 | Агентлаг болон бусад байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах сургалт, семинарт бүрэн хамрагдана | | Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх | | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | | Аймгийн төрийн албаны зөвлөлөөс “Шинэтгэлээр түчээлсэн салбар зөвлөл” аяны хүрээнд зохион байгуулсан төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, шинэтгэлийн бодлогын хэрэгжилтийн талаарх сургалтанд хэлтсийн албан хаагчид хамрагдлаа<br>Монгол улсын төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал баруун бүсийн зөвлөгөөнд 2 албан хаагч оролцлоо. Аймгийн тамгын газраас зохион байгуулсан “Дизайн сэтгэлгээ” 2 өдрийн танхимийн сургалт, Удирдлагын акдемиас зохион байгуулсан Монгол бичиг, жендерийн тэгш байдлыг хангах сургалтанд тус тус хамрагдаж хувь хүний хөгжил, мэдлэг ур чадвараа дээшлүүллээ. Аль болох сургалтуудад хэлтсийн албан хаагчдаа жигд оролцуулах бодлого баримталж сурч хөгжих боломжоор ханган ажиллаж байна. | 100% |
| 5.2 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад | | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан | ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж | | Ерөнхий газраас цахимаар зохион байгуулсан 19 сургалтанд бүрэн хамрагдлаа.<br>ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тогтоолуудын танилцуулга сургалт, Авлигалтай тэмцэх газраас зохион байгуулсан ХАСХОМ бөглөх сургалт, авлигалын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх сургалт, анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагагуудтай хийх гэрээний сургалтууд, 6 настнуудын эрт илрүүлэгийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтмол хамрагдана. | | | | мэдлэг, мэдээлэл авсан байна | | сургалт, мэдээллийн цаг зэрэг ерөнхий газраас зохион байгуулсан сургалт мэдээлэлд тус тус хамрагдаж мэдээллийг тухай бүр авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаа. | |
| 5.3 | Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ. | | Хамрагдсан сургалтын тоо | | Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна. | - | Монгол улсын төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал баруун бүсийн зөвлөгөөнд оролцож 2 өдрийн танхимын сургалтанд сууж хувь хүний хөгжил, мэдлэг ур чадвараа нэмэгдүүллээ. Мөн хувь хүний хөгжлийн сургагч багш бэлдэх хөтөлбөрт хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдэнэ хөтөлбөр гаргана хэлтсийн албан хаагчиддаа сургалт орж мэдээлэл хүргэн ажиллаж байна. | 100% |
| 5.4 | Монгол бичгийн мэдлэг чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах | | Хамрагдсан сургалтын тоо | | Албан хаагчдын үндэсний бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна. | - | Удирдлагын акдемээс зохион байгуулсан 120 цагийн монгол бичгийн сургалтанд хэлтсийн албан хаагчдын хамт хамрагдаж амжилттай төгслөө. Албан хаагчдын үндэсний бичгийн хэрэглээг сайжруулах албан бичгийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангаж ажилласан болно. | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Аймгийн засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг khovd.igovernment.mn сайтад тухай бүр гаргаж байршуулж биелэлтийг тооцуулан ажиллах | | Тухай бүр хэрэгжүүлэх | 2024 онд 13 шуурхай хурлын 24 үүрэг даалгаврын биелэлт гаргасан | Үүрэг даалгаврыг биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Аймгийн засаг даргаас өгсөн 15 үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж khovd.igovernment.mn сайтад тухай бүр байршуулж биелэлтийг тооцуулан ажиллаа | 100% |
| 2 | Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын сар бүрийн гүйцэтгэлийг санхүүд хүргүүлэх | | Тухай бүр хэрэгжүүлэх | 2024 онд хүлээн авсан нэхэмжлэлийн тоо 472618 | Сар бүр нэхэмжлэл хүлээн авч гүйцэтгэл хүргүүлэх | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын эхний 4 сарын 552 нэхэмжлэлийг сар бүрийн эхний 5 хоногт цахим хаягаар тулган хүлээн авч, гүйцэтгэлийг гарган баталгаажуулж санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлэн ажиллаа. | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ № 1 Өөрийгөө хөгжүүлэх хувь хүний хөгжлийн сургалтанд хамрагдах | Зохион байгуулагдсан сургалтын тоо | - Салбар байгууллагаас зохион байгуулагддаг сургалтууд хамрагдаж байсан. | Зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдсан байна. | Хувь хүний хөгжлийн институтаас зохион байгуулсан сургагч багш бэлдэх төлбөртэй сургалтанд өөрийн хүсэл сонирхлоор хамрагдаж амжилттай төгсөж төлөвлөгөө гарган хэлтсийн хамт олондоо хувиарын дагуу мэдээлэл хүргэж ажиллаж байна. | 1-5 сар | 100% |
| 2 | Арга хэмжээ № 2. Удирдлагын акдемиас зохион байгуулдаг мэргэшүүлэх сургалтад хамрагдах | - | Удирдлагын акдемиас зохион байгуулдаг мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байсан | Удирдлагын акдемиас зохион байгуулдаг мэргэшүүлэх сургалтад хамрагдаж сертефикат авах. | 2025 оны 4 сард Удирлагын акдемиас зохион байгуулсан “Жендрийн ахисан түвшний дүн шинжилгээ” сургалтанд хамрагдаж №:720573 дугаар бүхий сертефикат авлаа. | 4 сар | 100% |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* *Төсвийн шууд захирагч*

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .................... ( С.ЭНХБОЛД )

*(огноо)*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* *Нэгжийн дарга*

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА .................... (Б.ОЮУНЦЭЦЭГ)

*(огноо)* 20250627

..........................

*Тайлагнасан:* *Нэгжийн дарга*

ХОВД АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ .................... (М.ЦЭВЭЭНСҮРЭН)

*(огноо)*

2025.05.23